



Баянзүрх дүүргийн Статистикийн хэлтэс

ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА-2021



Улаанбаатар хот
2022 он



НИЙГМИЙН ДААТГАЛ,ХАЛАМЖ

Дүүргийн нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр 2021 онд өндөр насны тэтгэвэрт 173.7 тэрбум төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрт 21.8 тэрбум төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 6.4 тэрбум төгрөг, цэргийн тэтгэвэрт 34.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны нийт дүнгээс 14.5 тэрбум төгрөг буюу хувиар нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр
тэтгэмжийн төрлөөр

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид
тэтгэврийн төрлөөр

Нийгмийн даатгалын сангийн орлого, зардал
сангийн орлого, зардал

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн, төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр үйлчилгээнд зарцуулах нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгө байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОСОН ТЭТГЭВЭР

Үзүүлэлт	2018	2019	2020	2021
	тэрбум төгрөг			
Олгосон тэтгэврийн хэмжээ	166.9	190.9	221.7	236.2
Үүнээс:				
Өндөр насны тэтгэвэр	119.1	136.5	163.5	173.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	17.4	20.1	21.4	21.8
Тэжээгчээ алдсаны	4.9	5.5	5.9	6.4
Цэргийн тэтгэвэр	25.5	28.8	30.9	34.3

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧ, тоогоор

Үзүүлэлт	2018	2019	2020	2021
Олгосон тэтгэврийн хэмжээ	37 944	39 578	44 818	43 534
Үүнээс:				
Өндөр насны тэтгэвэр	27 208	28 546	35 677	32 403
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	5 638	5 865	7 210	5 608
Бусад (тэжээгчээ алдсан болон цэргийн)	5 098	5 167	1 931	5 523

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРДАЛ


Үзүүлэлт	2018	2019	2020	2021
	тэрбум төгрөг			
Нийгмийн даатгалын сангийн орлого	151.0	192.8	137.1	229.0
Нийгмийн даатгалын сангийн зардал	185.6	212.5	246.1	267.7
Үүнээс:				
Тэтгэврийн даатгалын сан	167.1	190.9	221.7	236.2
Тэтгэмжийн даатгалын сан	10.0	11.4	13.5	15.5
Ажилгүйдлийн даатгалын сан	6.5	8.2	8.8	13.9
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан	2.0	2.0	2.1	2.1

2021 оны гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангийн орлого 229.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 91.9 тэрбум төгрөгөөр буюу (67.0 %) хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлагын 88.2 хувийг тэтгэврийн даатгалын сангийн, 5.8 хувийг тэтгэмжийн даатгал, 5.2 хувийг ажилгүйдлийн даатгал, 0.8 хувийг ҮОМШӨ¹-ний даатгалын сангийн зардал тус тус эзэлсэн байна.

¹ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ, тэрбум төгрөг





Вэб сайт: www.1212.mn



Вэб сайт: www.ubstat.mn



Page: Баянзүрх дүүргийн Статистикийн хэлтэс